



МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН  
ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2018 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 10-09

Улаанбаатар хот

86

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.10, 20.11, Мэдээлэл, технологийн үндэсний паркийн Дүрмийн 4.3, 4.4.3 дэх хэсгийн заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. 2018 оны Мэдээллийн технологийн практик ур чадварын шалгалтын үйл ажиллагааны журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Тус журмыг дагаж мөрдөж ажиллахыг Гадаад харилцааны мэргэжилтэн /Б.Заяжаргал/-д үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Инноваци, технологи, судалгаа, хөгжүүлэлтийн хэлтсийн Бизнес хөгжүүлэлтийн ахлах мэргэжилтэн /П.Наранцэцэг/-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ц.СОДНОМДАМБА



Ерөнхий захирлын 2018 оны 03 сарын 02 өдрийн  
10-09. тоот тушаалын нэгдүгээр хавсралт

## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ПРАКТИК УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН ЖУРАМ

TOPCIT  
ТӨГӨЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү шалгалтын журам нь БНСУ-ын Мэдээлэл, харилцаа холбоо, технологийг дэмжих институт, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийг үндэслэн Мэдээллийн технологийн практик ур чадварын шалгалтын зохион байгуулалт, үүрэг, хариуцлагатай холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2. Журмын биелэлтэнд холбогдох хэлтэс, газар, төв хяналт тавина.
- 1.3. Шалгалт жилд 2 удаа явагдах бөгөөд онлайн хэлбэрээр зохион байгуулагдана.

### Хоёр. Шалгалтын бүртгэл

- 2.1 Шалгалтын талаарх мэдээлэл, шалгалтын бүртгэлийн зааврыг МТҮП-ийн вэб сайтад байрлуулсан байна.
- 2.2 Шалгалтын бүртгэл, шалгалт эхлэх өдрөөс нэг сарын өмнө Мэдээллийн технологийн практик ур чадварын шалгалтын цахим хуудас [/www.topcit.or.kr/](http://www.topcit.or.kr/) идэвхэжнэ.
- 2.3 Шалгалтын бүртгэлийн хугацаа шалгалт эхлэхээс 7 хоногийн өмнө хаагдана.
- 2.4 Бүртгүүлэхийг хүсэгчид цахим хуудас [/www.topcit.or.kr/](http://www.topcit.or.kr/)-д хандан өгөгдлийн маягтыг бөглөн онлайнаар өөрийн давтагдашгүй хэрэглэгчийн нэр /username/ болон нууц үгээр өөрийн хаяг /account/-ийг шинээр үүсгэн бүртгүүлнэ.
- 2.5 Өөрийн хаяг /account/ үүсгэсний дараа МТҮП-ийн дансанд төлбөр төлснөөр шалгалтын бүртгэл бүрэн баталгаажна.
- 2.6 Хэрэв шалгалтын бүртгэлийг цуцлахаар бол МТҮП-т хүсэлт гарган бүртгэлийн хугацаа дуусахаас 3 өдрийн өмнө цуцлуулж болно.

### Гурав. Шалгалтын хураамж

- 3.1 Шалгалтын хураамж 50,000 /тавин мянга/ төгрөг байна.

- 3.2 Бүртгүүлэгч нь шалгалтын хураамжийг МТҮП-ийн Голомт банкны 1102099876 тоот дансанд эсвэл МТҮП-ийн кассанд бэлнээр тушаана.
- 3.3 Бүртгүүлэгчид дараах шаардлагыг хангасан тохиолдолд шалгалтын хураамжаас хөнгөлөлт үзүүлнэ.
  - 3.1.1 Бүртгүүлэгч нь Мэдээллийн технологийн чиглэлийн их дээд сургуулийн оюутан бол шалгалтын хураамжийг 35%;
  - 3.1.2 Зөвлөлийн гишүүн байгууллагын ажилчдад 25%;
  - 3.1.3 Инкубаторын компаниудын ажилчдад 30%;
  - 3.1.4 Шаардлагатай тохиолдолд Стратегийн ач холбогдолтой байгууллага, хувь хүмүүст МТҮП-ийн захирлын зөвшөөрлөөр тодорхой хөнгөлөлтүүдийг үзүүлнэ.
- 3.4 Бүртгүүлэгч нь шалгалтанд ороогүй тохиолдолд шалгалтын хураамжийг буцаан олгохгүй, бусдад болон дараагийн шалгалтанд шилжүүлэн тооцохгүй.
- 3.5 Бүртгэлийг цуцалсан тохиолдолд шалгалтын хураамжийн 75%-ийг буцаан олгоно.
- 3.6 Бүртгүүлэгч нь шалгалтанд ороогүй тохиолдолд шалгалтын хураамжийг буцаан олгохгүй, бусдад болон дараагийн шалгалтанд шилжүүлэн тооцохгүй.

#### **Дөрөв. Шалгалтын дүн**

- 4.1 Шалгалтанд 5 түвшний 65 асуултаар нийт 1000 онооноос дараах байдлаар мэдлэгийн түвшинг тогтоон дүгнэнэ.
  - 4.1.1 Анхлан суралцагч /0-99 оноо/
  - 4.1.2 Суурь мэдлэгтэй суралцагч /100-399/
  - 4.1.3 Өрсөлдөхүйц чадвартай /400-699/
  - 4.1.4 Мэргэжлийн түвшиний /700-899/
  - 4.1.5 Зөвлөх түвшиний /900-1000/
- 4.2 Шалгалтын дүн шалгалт явагдсан өдрөөс хойш нэг сарын дараа мэдээлэх бөгөөд тухайн шалгуулагч бүртгүүлсэн цахим хуудсанд хандан өөрийн хаяг руугаа нэвтрэн орж харах боломжтой.
- 4.3 Шалгалтын дүнг нийтэд мэдээлэхгүй зөвхөн тухайн шалгуулагч хувийн хаяг руу явуулна.

#### **Тав. Гэрчилгээ олгох**

- 5.1. Шалгуулагч нь өөрийн мэдлэгийн түвшинг тодорхойлсон оноо бүхий гэрчилгээг шалгалтын цахим хуудсан дахь өөрийн хаягаар хүлээн авч баталгаажуулна

### Зургаа. Бусад

- 6.1 Шалгалттай холбоотой санал, хүсэлт, гомдлыг МТҮП-ийн холбогдох хэлтэс, газар, төвийн [exam@itpark.mn](mailto:exam@itpark.mn) цахим шуудангаар ирүүлж болно.